



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2015.03.16. № 351

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ-ын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн дагуу Нийслэлийн Аудитын газраас аудит хийв.

“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/ түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Нийслэлийн Аудитын газар нь “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ-ын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Нийслэлийн Аудитын газар нь аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ-ын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ-ын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, НББОУС,СТОУС түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц. ОЧИРБАТ

“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” НӨҮГ-ЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН



Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:

НАГ-ын дэд дарга:
Т.Сарантуяа

Утас: 327734

Аудитын менежер:
А.Цогбаяр

Ахлах аудитор
С.Гантөгс

Утас: 315558
Цахим хаяг:
tsogbayara@audit.gov.mn

НАГ-ын хаяг байршил:
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Лхагвасүрэнгийн гудамж
Цахим хуудас: city.audit.mn

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Менежментийн захидлын хариу

Хавсралт 5: Аудит хийсэн санхүүгийн тайлан

2015 оны 03 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Гол онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус заруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

1.Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.2, 18.2 дах заалтын дагуу Нийслэлийн аудитын газар “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ-ын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /НАГ-АХ-/2015/-СА-III-5-80/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн, Төрийн аудитын, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

“Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ-ын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /НББОУС/, Санхүүгийн тайлагналын олон улсын стаданрт /СТОУС/ түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт оршино.

“Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ нь жилийн эцсийн санхүүгийн тайлангаа НББОУС, СТОУС түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Нийслэлийн аудитын газрын үүрэг юм.

“Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ-ын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 3 дугаар сарын 10-наас 2015 оны 3 дугаар сарын 15-ныг хүртэл хугацаанд хийхээр төлөвлөн Нийслэлийн аудитын газрын санхүүгийн аудитын III багийн ахлах аудитор С.Гантөгс хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2015 оны 3 дугаар сарын 3-нд Нийслэлийн аудитын газарт ирүүлсэн байна.

Нийслэлийн аудитын газар аудитыг 2015 оны 3 дугаар сарын 3-наас 2015 оны 3 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайлан, гэрчилгээг 2015 оны 3 дугаар сарын 16-нд “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ-ын удирдлагад гардуулна.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ нь Төсвийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Компанийн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомжинд өөрчлөлт ороогүй байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Тус байгууллагын дүрмэнд “*Төрийн болон орон нутгийн өмчийн, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль болон Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдын хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамжуудыг удирдлага болгон улс, нийслэлийн төсөв зээл тусламжийн хөрөнгөөр барилга байгууламж шинээр барих, өргөтгөх шинэчлэн засварлах болон зураг төсвийн ажилд гэрээний үндсэн дээр гүйцэтгэлийн хяналт тавих, хөрөнгө оруулалтын бүртгэл мэдээлэл хөтлөх, хөрөнгө оруулалтын хэрэгцээг судлан дүн шинжилгээ хийж, үр дүнгийн саналаа холбогдох газруудад хүргүүлэх, Нийслэлийн Засаг даргын хот байгуулалт, хөрөнгө оруулалт хариуцсан орлогчийн ажлын хэрэгцээний мэдээлэл боловсруулах...*” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16.5 “*агентлагын дарга тус агентлагын төсвийн шууд захирагч байна*” гэж заасны дагуу Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ-ын дарга төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ-ын үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судлахад Төсвийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

“Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

**1. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим,
хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ-ын 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт, хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар 10-н аудитын хяналтын горим, 19-н нарийвчилсан сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаанд зохицуулан шинэчлэн боловсруулах зөвлөмжийг өмнөх оны аудитын явцад өгсөн боловч шинэчлэн боловсруулаагүй байна. Олон улсын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой нягтлан бодох бүртгэлийн програм нийцсэн байна. Харин хэрэглэгчдээс төвлөрүүлж байгаа орлогын програм санхүүгийн програмтай холбогдоогүй байна.

“Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

5. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь

материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ -ын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад санхүүгийн тзарим үйл ажиллагаанд дотоод хяналт хангалтгүй байна.

6. Орлого, зардал, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

“Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ нь 2014 оны зорилтот түвшингийн төлөвлөгөөнд борлуулалтын орлогыг 3,448,000.0 мянган төгрөг байхаар тусгаж, гүйцэтгэлээр 4,154,076.3 мянган төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 774,076.3 мянган төгрөг буюу 22.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

“Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ нь 2014 оны зорилтот түвшингийн төлөвлөгөөнд борлуулсан бүтээгдэхүүний өртөг 463,500.0 мянга, удирдлага, үйл ажиллагааны зардалд 1,899,765.0 мянга, үйл ажиллагааны бус зардалд 242,300.0 мянга нийт 2,605,565.0 мянган төгрөг байхаар төлөвлөж, гүйцэтгэлээр борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 359,063.8 мянга, удирдлагын зардалд 1,895,476.3 мянга үйл ажиллагааны бус зардалд 126,905.0 мянга, болон нийт 2,381,445.1 мянган төгрөгийг зарцуулж төлөвлөгөөг 224,119.9 мянган төгрөг буюу 8.6 хувиар хэмнэж, 1,617,704.4 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

7. Шинэн дансны мэдээлэл

Тус газар нь shilendans.gov.mn болон өөрийн сайтад байгууллагын 2015 оны 1, 2 дугаар сарын төлөвлөгөө, гүйцэтгэлийг байршуулсан байна.

8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 3 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын 6 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, ээлжийн амралтын болон үндсэн цалинг илүү олгосон, зардлын ангилалыг буруу бүртгэсэн зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, эрх ба үүрэг, үнэлгээ, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эдгээр эрсдэлүүд нь байгууллагын хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байх сөрөг үр дагаварт хүрч болзошгүй байна.

9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

“Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ-ын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний нийт 3,139,748.6 мянган төгрөгийн /мөнгөн хөрөнгө, бараа материал, авлага, өглөг, үндсэн хөрөнгө, орлого, тээвэр шатахуун, бичиг хэрэг, албан томилолт, сургалт, цалин хөлс /ажил гүйлгээ, үлдэгдэл тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь нийт орлогын 35.0 хувь, нийт зардлын 60.0 хувь, нийт хөрөнгийн 10.0 хувийг тус тус эзэлж байна.

10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний нийт 65,562.3 мянган төгрөгийн дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Тайлант хугацаанд шинээр үүссэн 32,043.2 мянган төгрөгийн авлага, 3,519.1 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг харилцагч байгууллага, хүмүүстэй тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.4. “... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах;” заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгснийг байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн байна.

2. Нийслэлийн аудитын газрын 2013 оны 1113 тоот албан бичгээр Татварын Ерөнхий газарт /ТЕГ/ Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрыг нэмэгдсэн өртгийн албан татвар /НӨАТ/ төлөгч болох үндэслэлтэй эсэхийг тодруулахаар явуулсан байна. ТЕГ-аас 2013 оны 8/3403 тоотоор нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч болох үндэслэлтэй гэсэн хариуг ирүүлсэн байна. Гэтэл Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст явуулсан НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх тухай албан тоотын хариуд 2014 оны 1/585 тоот албан бичгээр тус байгууллагыг "...3.6.12-т төрийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээ ..." гэх үндэслэлээр НӨАТ төлөгчөөр бүртгээгүй байна. Иймд дээрх 2 байгууллагын албан бичгүүд нь хоёрдмол утгатайгаар нэмүү өртгийн албан татвар төлөгч болох эсэх нь эргэлзээтэй болсон байна.

Шийдвэрлэсэн: Дээрх асуудлыг нэг мөр шийдвэрлүүлэхээр Хуульд албан ёсны тайлбар өгөх байгууллага болох Улсын дээд шүүхэд хандан эцэслэн шийдвэрлүүлэх зөвлөмж өгснийг зөвшөөрч уг байгууллагад хандан албан ёсны шийдвэр гаргуулахаар болсон байна.

Материаллаг бус дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Биет бус хөрөнгийн бүртгэлд ашиглахгүй байгаа 15,226.4 мянган төгрөгийн дансны үнэтэй 4,892.4 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй биет бус хөрөнгө байна.

Шийдвэрлэсэн: Дээрх нэр бүхий биет бус хөрөнгүүдийг эцэслэн шийдвэрлүүлэхээр өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн байна.

2. Байгууллагын даргын тушаалаар /ажилтан С.Батдэлгэр нь 2014 оны 1 дүгээр сарын 22-ноос/ 3 сарын чөлөө авсан ажилтан чөлөөний хугацаа дууссан боловч ажилдаа ороогүйгээр ажлаас халагдсан байна. Гэтэл тус ажилтны 1 дүгээр сарын цалинг бүтэн ажилласнаар тооцож 222.7 мянган төгрөгийг илүү олгосон, мөн даргын тушаалаар ажилтанд 1 сарын хугацаатай 20 хувийн сахилгын шийтгэл оногдуулсныг 29.2 мянган төгрөгөөр дутуу суутгажээ.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчилд нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

3. "Өөрчлөлтийг чиглүүлэгч төв" ТББ-аас байгууллагын ажилтнуудад зориулан зохион байгуулсан сургалтын төлбөрийг тооцооны дансаар дамжуулж бүртгээгүйгээс бусад байгууллагаас /НЗТХүрээлэн, НЗАА/ төлсөн 412.0 мянган төгрөгийн төлбөрийг урьдчилан төлсөн сургалтын зардлыг бууруулан бүртгэсэн

нь Санхүү, эдийн засгийн сайдын 2000 оны 116 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны үлгэрчилсэн заавар”-г холбогдох заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчилийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

4. Байгууллагын санхүүгийн тайланд гэрээ цуцлагдаж, ажил хийгдэхгүй нь тодорхой болсон, давхардан бүртгэсэн, он удаан жил хуримтлагдсан авлага, өглөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Шийдвэрлэсэн: Эзэн холбогдогч тодорхой бус, гэрээ цуцлагдсан авлага, өглөгүүдийг зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад асуудлын тавьж шийлвэрлэх зөвлөмж өглөө.

11. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад хууль, журам, заавар мөрдөөгүйгээс гарсан материаллаг болон материаллаг бус хэмжээний 65,562.3 мянган төгрөгийн алдааг залруулах боломжгүй байна.

12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал ажилтнуудын гадаад сургалт болон тэдгээрийн гүйцэтгэл, үр дүн, авлагын насжилт, эргэн төвлөрүүлж буй байдал зэрэг асуудал байгаа болно.

13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

“Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ-н 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцэт шалгаж амжаагүй эрсдэлтэй байж болох мөнгөн хөрөнгийн хөдөлгөөн, худалдан авч буй сэлбэг материалын асуудлыг завсрын аудитаар нөхөн шалгахаар тогтлоо.

14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ-ын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 66,226.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 412.0 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 251.9 мянган төгрөгийн зөрчлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, 65,562.3 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

“Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ-ын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Нийслэлийн аудитын газраас аудит хийж нийт 9 зөвлөмж өгсний 6-ыг бүрэн хэрэгжүүлж, 3 зөвлөмж хэрэгжүүлээгүй байна.

16. Зөрчилгүй санал дүгнэлт

“Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, НББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна


Аудитлагдсан санхүүгийн тайлан 4 хуудас, хавсралтууд 4 хуудас, байгууллагын санал 3 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

Нийслэлийн аудитын газрын

Дэд дарга:



Т.Сарантуяа

Аудитын менежер:




А.Цогбаяр

БЭЛТГЭСЭН:

Санхүүгийн аудитын

III албаны V багийн ахлах аудитор



С.Гантөгс